

2022 ОНЫ 05 ДУГААР САРЫН 02-НЫ ӨДРИЙН АЙМГИЙН УДИРДАХ АЖИЛТНУУДЫН ШУУРХАЙ
ХУРАЛДААНААС ӨГӨГДСӨН ҮҮРЭГ ДААЛГАВАР

2022.05.02

Дугаар 29

№	Өгөгдсөн үүрэг даалгаврын товч агуулга	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан	Биелэлт ирүүлэх хугацаа	Биелэлт
1	Сумдын эрүүл мэндийн төв болон газрын даамлуудын үйл ажиллагаанд хяналт тавих, үйл ажиллагааг нь жигдрүүлэх, иргэдэд түргэн, шуурхай, хүртээмжтэй, хүнд сурталгүй үйлчилгээ үзүүлэх нөхцөлийг бүрдүүлэх арга хэмжээ авч ажиллах	ЭМГ-ын дарга Н.Сакен ГХБХБГ-ын дарга К.Болат	V/05	
2	-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар сумдад баригдаж, ашиглалтад оролгүй, хөрөнгө оруулалт дутуу /үнийн зөрүү гарсан/ үндэслэлээр царцаагдсан барилгуудын нөхцөл байдалтай газар дээр нь танилцах, ашиглалтад оруулах арга хэмжээ авах -Ашиглалтад ороод удаагүй, чанарын болон ашиглалтын шаардлага хангахгүй байгаа барилгуудын нөхцөл байдалтай танилцах, дүгнэлт гаргах	ГХБХБГ-ын дарга К.Болат	V/05	
3	Өлгий сумын нутаг дэвсгэр дэх сэтэлсэн засмал зам, нөхөх шаардлагатай эвдрэлийн талаарх судалгааг гаргах. /хэн, ямар үндэслэлээр, хэзээ сэтэлсэн эсэх, төлбөрийг урьдчилан байршуулсан эсэх/ Замын сэтэлгээг нөхүүлэх, замын сангаас гаргах тооцоог танилцуулах.	МХГ-ын дарга Х.Бауыржан	V/05	
4	Аймгийн Цагдаагийн газрын орон сууцны барилга, Нурданеско хуримын ордны зам дагуух гэрэлтүүлгийг ашиглалтад оруулах талаар холбогдох аж ахуйн нэгж, байгууллагад албан бичиг хүргүүлэх	ГХБХБГ-ын дарга К.Болат	V/05	
5	-Төрийн албан хаагчдыг “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг”-т 2022.06.01-ний өдөр хүртэлх хугацаанд бүрэн хамруулах арга хэмжээ авах - Сумдын иргэдийг “Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг”-т хуваарийн дагуу хамруулах ажлыг зохион байгуулах	Нийт байгууллага, агентлаг Сумдын Засаг дарга нар	V/05	
6	2022.05.07-ны өдөр зохион байгуулагдах “Хэл, бичгийн шалгалт”-д ЕБС-ийн сурагчдыг сайтар бэлтгэх, бүрэн хамруулах талаарх үүрэг, чиглэлийг аймгийн хэмжээн дэх бүх сургуулийн удирдлагуудад хүргүүлэх	БШУГ-ын дарга Г.Амантай	V/05	
7	Бүтээн байгуулалтын ажлын улирал эхэлсэнтэй холбогдуулан түгээмэл тархацтай ашигт малтмал /хайрга/-ыг олборлох ажлыг хууль, журмын хүрээнд явуулахад хяналт тавих	ГХБХБГ-ын дарга К.Болат МХГ-ын дарга Х.Бауыржан	V/05	
8	Малын гоц халдварт шүлхий өвчинтэй холбогдуулан хөдөлгөөний хязгаарлалт тогтоосон сумдын хязгаарлалтыг цуцлах эсэх талаарх саналыг аймгийн Шуурхай штабт танилцуулан, шийдвэр гаргуулах	МЭГ-ын дарга А.Айдынасхар	V/05	

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР